

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2015-06-05

Тендер шалгаруулалтын нэр: **МУИС-ийн Е-номын сан болон хичээлийн 4-р байрны өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгох**

Тендер шалгаруулалтын дугаар: **НТ-15/09**

Монгол Улсын Их Сургууль нь эрх бүхий тендерт оролцогчдоос **МУИС-ийн Е-номын сан болон хичээлийн 4-р байрны өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгох нээлттэй тендерийг гүйцэтгэх** тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (**хүсвэл нэмэлт хувийг**) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **200000** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **2012, 2013, 2014 оны аль нэг жилд гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгээс доошгүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож байгаа үнийн дүнгийн 30%-с багагүй байна**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2012, 2013, 2014 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан /тодруулгын хамт/, 2015 оны эхний улирлын татварын албанд хянагдсан санхүүгийн тайлан**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жилд буюу 2013, 2014 онуудад нэгээс доошгүй удаа тендерт санал болгож буй үнийн дүнгийн 25%-иас багагүй үнийн дүнтэй барилга угсралтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажиллаж улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Уг ажлын гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын актын хуулбар, захиалагчийн тодорхойлолтыг тус тус ирүүлнэ.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Барилгын хуулийн 2.1.3, 2.2.1, 2.2.2 зүйл заалтууд

Тендерийн хамт 147,196,005.11 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2015 оны 7-р сарын 6** ний өдрийн **09** цаг **30** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2015 оны 7-р сарын 6** -ний өдрийн, **10** цаг **00** минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхтэй.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж 1, МУИС, Хангамж Үйлчилгээний Хэлтэс, Хичээлийн 1-р байр 213, 204 тоот, утас 321290, 321546